

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№20/524

ШУС, НУС

2019

**РАДИОГИЙН ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН НЭВТРҮҮЛГИЙН
ЗОРИЛТОТ БҮЛЭГ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ**

Т.Буянхишиг*

* МУБИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн докторант

Түлхүүр үг: радио, хүүхдийн нас сэтгэхүйн онцлог, хүүхдийн нэвтрүүлгийн зорилтот бүлэг, нийтлэл нэвтрүүлгийн бодлого

Хураангуй: Монголын радиогийн болон Өвөр Монголын Хөлөнбуйр хотын радиогийн хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн зорилтот бүлгээ хэрхэн сонгож, тэдний насны онцлог зэрэгт тохирсон нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж байгаа талаар дөхөм шинжилж, энэхүү бэсрэг өгүүллийг бичив. Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан нийтлэл, нэвтрүүлгийг бэлтгэх нь зорилтот бүлгээ зөв сонгож, тэдний насны онцлогт тохирсон нэвтрүүлгийн агуулгыг тохируулж бэлтгэх учиртай билээ. Энэ талаар МҮОНР болон Өвөр Монголын Хайлаар хотын радиогийн хүүхдэд зориулсан нэвтрүүлгийг нас сэтгэхүйн онцлог, зорилтот бүлэгт тохирч байгаа эсэхэд задлал хийж үзсэн болно.

Хүүхдийн нас сэтгэхүйн онцлог, нийтлэл нэвтрүүлгийн бодлогод тусгах нь. Хүүхдийн сэтгэл зүйн ертөнц тэр чигээрээ өвөрмөц, тайлагдашгүй онцлогтой байдаг. Үүнийг сэтгэл судлаачид, хүүхдийн уран бүтээлийг судлаачид онцгойлон анхаарч, тэдний өвөрмөц ертөнцийг ойлгох нь

уран бүтээл туурвих, сэтгүүл зүйн нийтлэл, нэвтрүүлгийг амжилттай хүргэх, бүтээхэд гол нөлөөтэй гэж үзсэн байдаг. Энэ талаар доктор, профессор Д.Оюунбадрах хүүхдийн уран зохиолыг олон жил судалсан судалгаандаа үндэслэн нас сэтгэхүйн онцлогийг тусгайлан гаргаж, онолын үндэстэй тайлбар хийсэн нь өнөөдрийн бидний баримтлах нэгэн чиг болж байна. Мөн өөр олон эрдэмтэн энэ талаар бүтээл туурвилдаа онцгойлон дурджээ.

Хүүхдийн нас сэтгэхүйн онцлог, насны үечлэлийг сэтгэл судлаачид өөр өөрсдийн үзэл баримтлалын үүднээс тайлбарлан бичсэн байх нь түгээмэл байна. Монголчууд эртнээс хүүхдийн насны онцлогийг зулбарай үе, нярай үе, балчир нас, бага нас, өсвөр нас, өсөх идэр нас¹ гэж нэрлэж, тэр насны онцлогийг харгалзан үр хүүхдээ хүмүүжүүлж ирсэн байна.

Харин сурган хүмүүжүүлэх ухааны онолын үүднээс бол нялх нас, цэцэрлэгийн өмнөх нас, сургуулийн өмнөх нас, сургуулийн өмнөх бага нас, сургуулийн өмнөх дунд нас, сургуулийн өмнөх ахлах нас, сургуулийн бага нас² гэж ангилж үзсэн бөгөөд олон улсад ч энэ ангиллыг баримтлах нь түгээмэл болжээ. Тухайлбал, судлаачид хүүхдийн нас сэтгэхүйн онцлогийг таван үе шатанд хуваасан байдаг байна. Энэ нь

нялх балчираас насанд хүрэх хүртэл 5 үе шат дамжин сэтэглзүйн онцлог нь хувирч байдгийг харуулсан хэрэг юм. Үүнд, 1-р үе шат, нярайн үе, 2-р үе шат, бага нас, 3-р үе шат, зугаацах, наадах нас, 4-р үе шат, сургуулийн нас, 5-р үе шат, шилжилтийн буюу хямралын нас гэж хуваадаг байна. Тэгэхээр энэ насны онцлог, үе шатыг хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлэгт харгалзан үзэхгүйгээр зорилтот бүлгээ зөв сонгож чадахгүй, тэдний үзэх, сонсох нийтлэл, нэвтрүүлгийг бид хийж чадахгүй юм.

Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогийг харгалзан, зорилтот бүлэгт тохирсон нэвтрүүлгийг бэлтгэх ажлыг хийхгүй бол хүүхдүүд сонсохгүй, сонсоод ч ойлгохгүй учраас программын бодлогодоо ягштал тусгах, баримтах шаардлагатай болж байна. Тиймээс хүүхдийн насны онцлогийг харгалзан үзэх нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэх учиртайг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулинд тусгайлан зааж өгчээ. Тус хуулийн 8.2.6-д *“Хувь хүний болон нийгмийн хөгжлийг дэмжих, ялангуяа хүүхэд, залуучуудын оюуны болон бие бялдрын хөгжилд онцгой анхаарах;”*³ гэж заасан бөгөөд мөн 9.7 дахь заалтад *“Энэ хуулийн 8.2.6-д заасан нэвтрүүлэг нь залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийн тусгайлан тогтоосон цагтай байна”*⁴ гэж хүүхдэд зориулсан нэвтрүүлэг нь тусгайлан цагтай байхыг онцгойлон тусгаж өгсөн байна.

Хүүхэд гэдэг бол өвөрмөц ертөнц, хамгаалах ёстой, элдэв муу зүйлээс байнга хаацалж байх ёстой нандин эрдэнэ. Тиймээс радио, телевиз болон сонин хэвлэлээр хүүхдийн эрхийг хүндэтгэсэн, тэдний аливаа эрхийг зөрчсөн нийтлэл нэвтрүүлэг явуулж болохгүй. Энэ талаар “Хүүхэд хамгааллын тухай”⁵ хуулийн 8-р зүйлд “Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь

хүүхэд хамгаалал” гэсэн тусгайлан зааж өгсөн байдаг. Тэгэхээр бид хүүхдийн нэвтрүүлэгт ихээхэн анхаарч, алдаа эндэгдэл гаргахаас ямагт сэргийлж явах учиртай юм. Тиймээс Олон нийтийн радиогийн хуулинд энэ талаар мөн тусгайлан заасан байсныг ч бид харгалзан үзэж, нэвтрүүлгийн бодлого, үйл ажиллагаандаа тусгах ёстой юм.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 9.5-д “Хуулиар хориглоогүй боловч хүүхэд, залуучуудын бие махбодь, оюун санаа, зан суртахуунд сөргөөр нөлөөлж болохуйц агуулга бүхий нэвтрүүлэг, баримтат болон уран сайхны киноны дамжуулах цагийг зохицуулах, эсхүл техникийн бусад арга хэмжээг ашиглах замаар хязгаарлалт тогтоож болно...”⁶ гэж зааж өгсөн байна. Энэ нь хүүхэл хамгааллын бас нэгэн илэрхийлэл мөн.

Тэгвэл БНХАУ-ын хэмжээнд хүүхдийн нэвтрүүлгийг мөн л нас сэтгэхүйн онцлогт тохируулан хийж байх тухай тус бүртээ өөр өөрийн журам, дүрмээр зохицуулж ирсэн байна. Тухайлбал, ӨМӨЗО-ны Хайлаар хотын Радио, телевиз хорооны дүрэмд *“1. Хүүхдийн нас бие сэтгэхүйн онцлогийг харгалзан үзэх хэрэгтэй, 2. Эрүүл саруул агуулгатай байх, 3. Радиогийн хүүхдийн нэвтрүүлгийн нэг удаагийн нэвтрүүлгийг 30 минутаас хэтрүүлэхгүй байх, 4. Хүүхдэд ойлгомжтой дөхөм авсаархан үг хэллэгтэй байлгах, 5. Хүүхдийн нэвтрүүлгээр реклам зар сурталчилгаа явуулж болохгүй, 6. Эх улсаа хайрлах, улс үндэстнээ хайрлах, нийгэм журамт тэргүүний соёлыг суралцах, 7. Радиогийн багачууд хүүхдийн нэвтрүүлгийн агуулгыг сурган хүмүүжүүлэх чанар, мэдлэгт чанар, сонирхолт чанар, тоглоом цэнгээнт чанартай байх хэрэгтэй, 8. Хүүхдийн*

нэвтрүүлгийн сэтгүүлчид бусад уран бүтээлчдийг бодвол илүү их мэдрэмжтэй байх хэрэгтэй. Учир нь хүүхэд аливааг даган дууриахад бэлэн сэтгэхүйтэй байдаг”⁷ гэж тусгайлан зааж өгчээ.

Радиогийн хүүхдийн нэвтрүүлгийн зорилтот бүлэг, түүнд зориулсан нэвтрүүлгийн тухай товчхон.

Энэ бүхнийг үндэслэн 2010 оноос эхлэн МҮОНР-гийн Сургууль хүүхдийн редакц, Хүүхэд Залуучуудын редакц гэж байгаад одоо Хүүхэд, залуучуудын редакц болон ажиллаж байна.

Цэцэрлэгийн хүүхдүүдээс эхлээд оюутан сурагчид, ахлах насныхан, цаашлаад эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчид энэ редакцын идэвхтэн сонсогчид байдаг юм. Өнөөдрийн байдлаар тус редакц нь 4 сурвалжлагч, 2 редактор, тоймч, ерөнхий редактор гэсэн бүрэлдэхүүнтэйгээр 7 хоногтоо 300 минутын нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэн ажиллаж байна. Тэдний нэвтрүүлгийг зорилтот бүлгээр нас сэтгэхүйн онцлогт хэрхэн тохируулж буйг ажиглав.




График 1. МҮОНР-гийн хүүхдийн нэвтрүүлэг зорилтот бүлгээр

Хүүхдэд зориулан хүргэдэг нийт нэвтрүүлгээс давхардсан тоогоор цэцэрлэгийн хүүхдэд 3, бага ангийнханд 5, дунд ангийнханд 4, ахлах ангийнханд зориулсан 5 нэвтрүүлэг байна. Эндээс үзэхэд сурагчид, ялангуяа ахлах ангийнханд зориулан бэлтгэн хүргэдэг хүүхдийн нэвтрүүлэг илүү олон байна.

Бага насны хүүхдийг амьдралтай танилцуулах, танин мэдэхүйг нь хөгжүүлэх, янз бүрийн ур чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн нэвтрүүлгийг тоглоомын болон хөгжөөн баясгах аргаар бэлтгэх нь илүү үр дүнтэй байдаг.

Бага насны хүүхдийн үг, яриаг ойлгох чадвар эрчимтэй хөгжиж, хэл яриаг дууриах чадвар улам сайжирч үгийн баялаг нэмэгдэж байдаг.

Харин 5 наснаасаа хэлж байгаа үгийн утга санааг олж мэдэхийг эрмэлздэг онцлогтой. Энэ онцлогийг харгалзан үзэж нэвтрүүлгээ бэлтгэх нь чухал.

Хүүхдийн бага насанд гэр бүл, үе тэнгийнхэн нь нийгэмшихэд нь гол үүрэг гүйцэтгэдэг бол 15-17 насанд нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл тун их үүрэг гүйцэтгэдэг байна. Хүүхдүүд томчуудтай илэн далангүй байж, мэдэхгүй чадахгүй зүйлээ тэр бүр асууж чаддаггүй болохоор мэдээллийн хэрэгсэлтэй дотно нөхөрлөдөг. Тэр хэрээрээ хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүч нөлөөнд амархан автдаг. Харамсалтай нь өнөөдөр хэвлэл мэдээллийн хэрэглүүдэд хүүхдийн тухай нэвтрүүлэг, нийтлэл ердөө 1 хувийг л эзэлдэг⁸. Түүнчлэн интернет гэх чөлөөт орон зай хүүхдүүдийн авч буй мэдээллийг хянах

боломжийг олгохгүй байгаа нь хүүхдүүд зөв буруу олон мэдээллийг олж авахад хүргэж байна. Үүний дээр сэтгүүлчдийн хүүхдийн асуудлыг хөндөж байгаа сэдвийн тал хувь нь сөрөг байр сууринаас хандаж байгаа талаар судлаачид шүүмжилж байна. Ийм нөхцөлд МҮОНР төлөвших насан дээрээ байгаа хүүхдүүд рүү нэвтрүүлгээ чиглүүлж байгаа нь олзуурхуштай юм.

Нийт нэвтрүүлгийн 70 хувийг хүүхдийн мэдлэгт зориулсан хичээл

боловсрол олгох, танин мэдэхүйн үүрэг бүхий нэвтрүүлэг эзэлж байгаа нь үр өгөөжтэй юм. Үлдсэн 30 хувийг хүүхдэд зориулсан цаг үеийн мэдээ мэдээлэл эзэлж байна. Мэдээллийн нэвтрүүлэгт олон жилийн өмнө бий болсон уламжлалт “Өглөөний мэнд” нэвтрүүлэг багтаж байна. МҮОНР-д сүүлийн үед хөтөлбөртөө боловсрол, танин мэдэхүйн чиглэлийн нэвтрүүлгийг түлхүү оруулсан байна. Үүнийг доорх үзүүлэлтээс харж болно.




График 2. МҮОНР-гийн хүүхдийн нэвтрүүлгийн үндсэн чиглэл

Монгол Улсын радиогийн нэвтрүүлэг нь сургалт, танин мэдэхүй, мэдээллийн гэсэн төрөл нь давамгайлж байна. Энэ нь тус улсын нэвтрүүлгийн бодлого, үйл ажиллагааны чиглэлтэй хамаатай зүйл юм.

Харин БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хайлаар хотын Радио, телевизийн хорооны радиогийн хүүхдийн нэвтрүүлэг нь хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан олон янз байдалтай биш бөгөөд голчлон “Алтан хонх” нэвтрүүлэг явуулж, түүний дотор олон булан, мэдээллийн чиглэлээр хүүхдийн насны онцлогийг харгалзан мэдээ нэвтрүүлж

байна. Тус нэвтрүүлэг нь анх 7 хоногт 1 цагаар нэвтрүүлдэг байсан бол 2018 оны 6-р сараас эхлэн 1,30 цагаар нэвтэрч эхэлсэн байна. 11 тогтмол булангаар дамжуулан хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон мэдээ, мэдээллийг хүргэж байна.

Доорх графикт ӨМӨЗО-ны “Алтан хонх” нэвтрүүлгийн чиглэлийг үзүүлэв. Энэ радио танин мэдэхүйн чиглэлийг түлхүү барьж, зугаацуулах, мэдээлэх чиглэлийн нэвтрүүлгүүд адил түвшинд байна. Дээр дурьдсан гурван чиглэл зарим нэвтрүүлэгт давхардсан тал түгээмэл бий.



График 3. "Алтан хонх" нэвтрүүлгийн булангийн чиглэл

Манай улсын хувьд хүүхдийн нэвтрүүлэг нь дөхөмхөн зугаацуулах, танин мэдүүлэх, мэдээлэх чанартай байх нь гол байдаг. Сургалтын чиглэлийг төдий л баримтлахгүй бөгөөд насны онцлогт тохируулан ахлах насны

хүүхдэд заримдаа сургалтын шинжтэй нэвтрүүлэг бэлтгэж хүргэдэг. Ялангуяа бага насны хүүхдэд зориулсан нэвтрүүлгийг зугаацуулах чанарт тулгуурлан хийх бүр чухалчилж байна.




График 4. МҮОНР-гийн хүүхдийн нэвтрүүлгийг зорилтот бүлгээр

Дээрх үзүүлэлтийг зорилтот бүлгээр нь авч үзвэл танин мэдэхүйн нэвтрүүлэг цэцэрлэгийн насныхан мөн бага ангийнханд зориулагдаж байгаа бол дунд болоод ахлах ангийнханд хичээл сургалттай холбоотой нэвтрүүлэг, харин мэдээллийн нэвтрүүлэг дунд болоод ахлах ангийнхан руу чиглэж байна.

Доорх хүснэгтэд Өвөр Монголын радиогийн "Алтан хонх" нэвтрүүлгийн булангуудыг үзүүлэв. Монголын ёс заншил, хэл соёлоо авч үлдэхэд ардын

аман зохиолыг радиогоор түгээн дэлгэрүүлэх нь тодорхой хувь нэмэр болно хэмээн энэ радиогийн хамт олон үздэг. Тийм ч учир "Алтан шагай", "Үлгэрийн өргөө" "Билгийн тооно" зэрэг буланг ийм агуулгаар бэлтгэж байгаа юм. Хэлц үг, өвөрмөц хэллэг, оньсого, үлгэр, туульс, оньсого, оюуны тоглоом, үг үгсийн таавар хэлэлцэж, үлгэр өгүүлдэг. Бага насны хүүхдүүдэд зориулагдаг учир нэвтрүүлгийн ихэнх хэсгийн агуулга хүүхдийн танин мэдэхүүд чиглэнэ.

Хүснэгт 1. “Алтан хонх” нэвтрүүлгийн булангуудын танилцуулга

№	Булангийн нэр	Агуулга	Ардын аман зохиол ашигласан эсэх
1	“Нусгай жаал”	Хүүхдүүдийн нэг долоо хоногийн турш болсон үйл учрал, алдаа оноог өөрөөр нь яриулах, эцэг эхчүүд, багш ахмад, үе тэнгийн найзуудтай нь харилцан яриулах зорилготой.	үгүй
2	“Алтан шагай”	Монгол соёл зан заншил, түүх соёлыг өвлөн залгамжуулах зорилготой	Хэлц үг, өвөрмөц хэллэг, оньсого
3	“Улаан бүч”	Хүүхдийн шүлэг зохиолоос хүргэх	Уламжлалтай холбоотой шүлэг зохиол
4	“Үлгэрийн өргөө”	Ардын үлгэр, туульс сонсгодог	Үлгэр туульс
5	“Дууч шувуухай”	Хүүхдийн ая дууг захиалгаар сонсоно	Ардын дуу хөгжим
6	“Билгийн тооно”	Оньсого таалцаж, оюуны тоглоомоор наадаж, монгол үг үсгийн таавар	Оньсого, оюуны тоглоом, үг үгсийн таавар
7	“Хуулийн эзэд”	Хүүхдэд хуулийн мэдлэг олгоно	үгүй
8	“Бийртэй багачууд”	Амжилттай яваа хүүхдийн түүхийг хүргэдэг	үгүй
9	“Хөгжилтэй Монголдой”	Цэцэрлэгийн хүүхдэд зориулалттайгаар тэдний амьдралд гүнзгийрэн наргиантай болгох талын агуулгатай	үгүй
10	“Болжморын жиргээ”	Хүүхдүүд утсаар шууд холбогдож дуу дуулж, шүлэг уншдаг	Ардын дуу, яруу найраг
11	“Нууцлаг ертөнц”	Байгалийн болон ан амьтан, ургамлыг танилцуулдаг	Уламжлалт заншил

Хайлаар хотын Радио, телевизийн хорооны нэвтрүүлэг нь нэг цогц шинжтэй бөгөөд нас насны онцлогт тохируулсан булантай байдаг нь МҮОНР-гийн нэвтрүүлгээс ялгарч байна. Монголын радиогийн хувьд хүүхдэд зориулсан олон нэвтрүүлэгтэй, тэдний цаг ахиу байгаа нь Өвөр Монголын Хайлаар хотын радиогоос давуулаг байна. Мөн нас насны хүүхдийн онцлогт тохирсон олон тусдаа нэвтрүүлэг явуулдаг нь судалгааны явцад ажиглагдаж байна. Энэ нь манайд цаашид үлгэрлэн хэрэгжүүлвэл

зохилтой сайн жишиг юм. Олон нийтийн радио, телевизийн хуулиар нэвтрүүлгийн бодлого, үйл ажиллагаа нь заагдсан учир хэрэгжүүлэхэд амар дөхөм байгаа нь манай улсынхаас давуу талтай гэж дүгнэж болох юм.

Дараах хүснэгтээс МҮОНР нь олон талын нэвтрүүлэг бэлтгэж, хүүхдийн насны онцлогт тохируулан гаргах талд давуулаг байгааг харуулж байна. Цаашлаад Өвөр Монголын радиогийн хөтөлбөрт Монголын радиогийн жишгийг дагаж, шинэчлэн сайжруулах олон ажил байгааг харуулж байна.

Хүснэгт 2. МҮОНР-гийн хүүхдийн нэвтрүүлгийн хугацаа, давтамж

№	Нэвтрүүлгийн нэрс	Зорилтот бүлэг	Үргэлжлэх хугацаа /минут/	Нэвтрэх давтамж /7 хоногор/
1	Өглөөний мэнд	Бага, дунд, ахлах	10	5
2	Радио цэцэрлэг	Цэцэрлэгийн хүүхдүүдэд	10	1
3	Миний ертөнц	Ахлах ангийнхан	40	0.5
4	Чээж бичиг	Бага, дунд ангийнхан	20	1
5	Хамтдаа хөгжье	Дунд, ахлах ангийнхан	15	2
6	Байгаль хүүхэд	Цэцэрлэг, бага ангийнхан	10	1
7	Цэцэн үг цээжинд	Цэцэрлэг, бага ангийнхан	10	1
8	Үдшийн үлгэр	Бага, дунд ангийнхан	15	7
9	Боловсрол	Бага ангийнхан	20	1
10	Дэгдээхэй үүрэндээ жигүүрлэдэг	Дунд, ахлах ангийнхан	40	0.5
11	Радио конкурс	Ахлах ангийнханд	20	1

Харин Өвөр Монголын радио нь тогтмол нэвтрүүлэгтээ нас насны хүүхдэд зориулсан буланг нэвтрүүлдэг бөгөөд харин Ахлах ангийнханд зориул-

сан булан байхгүй байгаа нь тэдний онцлогийг харгалзсан сонирхолтой нэвтрүүлэг дутагдаж байгааг харуулж байна.

Хүснэгт 3. Өвөр Монголын радиогийн булангийн тоо

№	Насны ангилал	Өвөр Монголын радиогийн булангийн тоо
1	Цэцэрлэгийн насныханд зориулсан	6
2	Бага ангийнханд зориулсан	8
3	Дунд ангийнханд зориулсан	2
4	Ахлах ангийнханд зориулсан	-

МҮОНР-гийн хүүхдийн нэвтрүүлгүүд болон Өвөр Монголын Хөлөнбуйр хотын радиогийн монгол хэлээр явуулдаг нэвтрүүлгүүдийг харьцуулан судлахад зорилтот бүлгийг тодорхойлох, тэдэнд тохирсон сэдэв агуулгаа сонгох, нэвтрүүлгээ тоглоомын болон танин мэдэхүй, хөгжөөнт, шууд, уралдаант гэх зэрэг хэлбэрээр хүргэх гэсэн зорилго ижил байна. Хүүхдүүдийн бүтээлч оролцоог дэмжих, тэдэнд амьдрах ухааны болоод хүн болох эрдэм, сэтгэл зүйн боловсрол мэдлэг олгох зорилгын хүрээнд олон бүтцээр хийж байгаа, мэдээллийг олон талаар нь цогц өгөх гэсэн сэдэл нь ч мөн ижил байна. Мөн дээрх хоёр радиод нэг ижил төстэй тал байгаа нь ардын аман

зохиолыг нэвтрүүлэгтээ ашиглаж байгаа байдал юм.

Харин Хөлөнбуйр хотын радиогийн хувьд нэвтрүүлгийн бодлого, төлөвлөлт, бүтцийг тодорхойлох, ярих гол сэдвийн өнцгийг задлах зэрэг радиогийн өнөө цагийн үйл ажиллагааны зайлшгүй байх зарчмын шаардлагууд зарим талаар байхгүй байгаа нь анзаарагдав. Монголын радио барууны болоод Шведийн радиогийн туршлагаар энэ арга замуудыг ажилдаа хэрэгжүүлж байгаа нь нэвтрүүлгийн чанар сайжрах бодит гарц болжээ.

Дүгнэлт

1. Монголын Үндэсний Радио нь Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, нэвтрүүлгийн бодлого, төлөвлөлт нь явдаг тул хүүхдэд зориулсан нэвтрүүлгийг зорилтот бүлэгт чиглүүлэх талд ахицтай байгаа нь анзаарагдав. Харин БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хайлаарын радиогийн хувьд хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон нэвтрүүлэг ганцхан байх бөгөөд булангуудаар насны онцлогийг харгалзан үзэж, нэвтрүүлдэг болох нь судалгаанаас харагдаж байна.

2. ӨМӨЗО-ны Хайлаар хотын радио нь тусгайлсан хууль, дүрэм байхгүй ч гэлээ дотоод журмаараа хүүхдийн нэвтрүүлэгт тавигдах шаардлагыг баталж, үүнийгээ ягштал баримталдаг байна.

3. Монголын радиогийн хүүхдийн нэвтрүүлэг нь голчлон сургалт, танин мэдэхүй, мэдээлэх чиглэлтэй байдаг бол ӨМӨЗО-ны Хайлаар хотын Радио, телевизийн хорооны монгол хэлээр дамжуулдаг хүүхдийн нэвтрүүлэг нь танин мэдэхүй, зугаацуулах, мэдээлэх чиглэл давамгайлж байгаа нь тус улсын хэвлэл мэдээллийн салбарт барьдаг бодлого үйл ажиллагаатай нь холбоотой байна.

4. Цаашид ӨМӨЗО-ны радиогийн нэвтрүүлэг нь олон талт болж, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон нэвтрүүлгийн олон хэлбэр, төрлийг ашиглаж, нэвтрүүлэг бэлтгэхэд монголын радиогийн хүүхдийн нэвтрүүлгийн зорилтот бүлэгтээ хүрч ажилладаг туршлагыг харгалзан үзвэл зохино.

Ишлэл

¹ Дамбийжанцан Х., “Монгол зан үйлийн зүй”, Өвөр Монголын Лёонаны үндэсний хэвлэлийн хороо, Лёонан хот, 1999, х.29.

² Батдэлгэр Д., Бага насны хүүхдийн сэтгэл судлал, УБ, 2011, х.46.

³ Монгол улсын хууль, Олон нийтийн радио, телевизийн тухай, 2005 оны 1 дүгээр сарын 27. Улаанбаатар хот, <https://www.legalinfo.mn/law/details/424?lawid=424>

⁴ Мөн тэнд. <https://www.legalinfo.mn/law/details/424?lawid=424>

⁵ Монгол улсын хууль, Хүүхэд хамгааллын тухай, 2016 оны 2 дугаар сарын 16. Улаанбаатар хот <https://www.legalinfo.mn/law/details/11710?lawid=11710>

⁶ Монгол улсын хууль, Олон нийтийн радио, телевизийн тухай, 2005 оны 1 дүгээр сарын 27. Улаанбаатар хот, <https://www.legalinfo.mn/law/details/424?lawid=424>

⁷ БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хайлаар хотын Радио, телевизийн хорооны дүрэм, Хайлаар хот, 2010.

⁸ МХХ, Хүүхдийг ивээх сан. Хүүхэд ба олон нийтийн мэдээлийн хэрэгсэл. -УБ., 2008. х.9.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Батдэлгэр Д. Бага насны хүүхдийн сэтгэл судлал. 2011. УБ.
2. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хайлаар хотын Радио, телевизийн хорооны дүрэм. 2010. Хайлаар хот.
3. Буянхишиг Т. Радиогийн хүүхдийн нэвтрүүлгийн өнөөгийн байдал, хөгжлийн хандлага, Сэтгүүл зүйн магистрын зэрэг горилсон бүтээлийн бичвэр, 2017. УБ.
4. Дамбийжанцан. “Ардын уламжлалт зан үйл”. 2016. Хайлаар хот. Өвөр Монголын Соёлын хэвлэлийн хороо.
5. Монгол улсын хууль, Олон нийтийн радио, телевизийн тухай, 2005 оны 1 дүгээр сарын 27. Улаанбаатар хот, <https://www.legalinfo.mn/law/details/424?lawid=424>
6. Монгол улсын хууль, Хүүхэд хамгааллын тухай, 2016 оны 2 дугаар сарын 16. Улаанбаатар хот <https://www.legalinfo.mn/law/details/11710?lawid=11710>

7. МХХ, Хүүхдийг ивээх сан. Хүүхэд ба олон нийтийн мэдээлийн хэрэгсэл. 2008. УБ.

Summary

In this paper, selection criterion and preparation of radio program for different age-group children, which were broadcasted in Mongolia and Hulun Buir city of China, were

studied. Radio program carefully prepared considering juvenile psychological characteristics requires proper selection of main theme and contents. In this respect, whether juvenile radio program of Mongolian National Radio and Hulun Buir Radio Station better fitted to children's psychological characteristics and main theme was analyzed.